



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/065/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч: Я.Самбууням
Утас:264230 Цахим хаяг:sambuunyamy@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Батсүх
Утас: 261628 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261628 Цахим хаяг: lkhaqvasuren@audit.gov.mn
Аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

Г ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН Г
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Х.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2025.04.09 № 1410

танай _____-ны № _____-т

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 38,869.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн өмчит компаниудад 2018 оноос эхлэн 6,865,752.5 сая төгрөгийн зээл, санхүүжилтийг нийт 14 төсөл арга хэмжээнд олгосноос тайлант онд 4 төсөл арга хэмжээг 693,924.1 сая төгрөгөөр санхүүжүүлсэн;
- Тайлант онд эргэн төлөгдөх 25,775.0 сая төгрөгийн зээл, санхүүжилтийн авлагыг барагдуулаагүй;
- Санхүүгийн тайланд ногдол ашгийн хуваарилалттай холбоотой үүссэн 1,215.3 сая төгрөгийн татварын авлага, харилцагч тодорхойгүй 2,817.7 сая төгрөгийн ногдол ашгийн өглөгийг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй;
- Уурхайн цэвэрлэх байгууламж барих 1,690.2 сая төгрөгийн гэрээт ажил хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10, 46.13, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайланд хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа 7 харилцагчтай холбоотой 17,666.2 сая төгрөгийн авлага, нэг харилцагчтай холбоотой 1,032.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг толилуулсан байна.

Чингис хаан банкнаас авах 2021 онд шүүхийн шийдвэр гарсан 65,503.2 сая төгрөгийн, 2022 онд шийдвэр гарсан ЖиСТАТС Консалтинг ХХК-аас авах 557.2 сая төгрөгийн авлага барагдаагүй байна.

Дотоодын зах зээлд 2021 онд гаргасан 306.9 тэрбум төгрөгийн Транч-2-1, Транч-2-2 бондын үндсэн төлбөр, 92.1 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай" 58 дугаар тогтоолоор тус компанид нөлөө бүхий дараах шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

- Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;
- Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох;
- Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонноос бууруулахгүй, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх гэж тус тус заасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тавантолгой ордын бодит чадавхийг тодорхойлох, ордын нөөцийг бүрэн ашиглах, цогцоор хөгжүүлэх зорилгоор геологи, хайгуул, судалгааны ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, Цанхи, Бортээг, Оорцгийн хэсэгт үндсэн 12 давхраас, дэд 34 давхраасын

хэмжээнд нийт 117 багц үеийг нарийвчлан ялгаж, тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөцийг 29.0 хувиар нэмэгдүүлэн, нүүрсний нөөц баялгийг 8.1 тэрбум тонн болгон шинэчлэн тогтоож, Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 45 дугаар тогтоолоор 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд тус компанийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 09 дүгээр тогтоолоор тус компанитай холбоотойгоор төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээ авах, МТАС түншлэлтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох тухай” шийдвэр гарсан байна. Үүнтэй холбоотойгоор тус компанийн бизнес төлөвлөгөөнд тусгасан Бортээгийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг зогсоосон байна.

Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар тогтоол, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр тогтоолоор Тавантолгой төмөр зам ХХК-ийн 34.0 хувийн хувьцааг эзэмшиж байгаа Монголын төмөр зам ТӨХК-аас гаргасан 750.0 тэрбум төгрөгийн бондоос суутган тооцох, бондын үлдэгдэл төлбөрийг барагдуулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна.

Бусад асуудал

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нүүрсний нээлттэй цахим арилжаанд 2023 оны 02 дугаар сараас эхлэн оролцож, тайлант онд 115 удаагийн арилжаагаар хил нөхцөлөөр 2,836.4 сая ам.долларын 25.0 сая тонн нүүрс борлуулснаас тайлант онд 50 удаагийн арилжаагаар 1,571.6 сая ам.долларын 15.2 сая тонн нүүрс борлуулсан байна.

Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангахад урт хугацааны стратеги төлөвлөгөөг оновчтой тодорхойлох, холбогдох тогтоол шийдвэрийн хүрээнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах, Эрдэнэс Монгол ХХК-ийн баталсан стратеги төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг хэрэгжүүлж байна.

Компанийн засаглалын бодлого /кодекс/-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, олон улсын засаглалын зарчимтай уялдуулан боловсруулах ажил 30.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,564,192,921,300.34	1,431,077,104,112.02
1.1.2	Дансны авлага	550,665,114,196.67	718,079,593,745.89
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	18,122,595,802.18	1,215,648,808.41
1.1.4	Бусад авлага	64,782,050,738.85	258,854,421,891.37
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	366,734,620,712.47	506,601,074,821.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,155,005,031,490.95	2,821,204,095,428.11
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,719,502,334,241.46	5,737,031,938,807.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,232,751,118,355.41	2,126,210,634,486.61
1.2.2	Биет бус хөрөнгө	11,063,983,254,443.70	11,087,027,404,581.34
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,346,763,751,000.00	1,346,763,751,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	18,783,644,399.63	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	121,646,587,139.31	-
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,396,180,912,636.39	3,752,946,810,979.70
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,180,109,267,974.44	18,312,948,601,047.65
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,899,611,602,215.90	24,049,980,539,854.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	162,741,152,109.28	204,342,698,318.92
2.1.1.2	Цалингийн өглөг	6,601,970,702.94	10,139,502,388.68
2.1.1.3	Татварын өр	710,401,949,735.20	456,685,034,816.66
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	306,875,700,000.00	-
2.1.1.6	Хүүний өглөг	7,802,577,122.80	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	3,305,196,752,456.20
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,671,694,661,445.35	1,330,234,984,371.79
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,817,769,320.00	362,330,561,858.78
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,868,935,780,435.57	5,668,929,534,211.03

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/ УХ	173,827,288,075.96	165,372,780,665.81
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	6,683,214,480.97	38,328,000,367.01
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	762,988,699,600.00	762,988,699,600.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	943,499,202,156.93	966,689,480,632.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,812,434,982,592.50	6,635,619,014,843.85
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.4	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	75,036,228,890.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	5,891,176,619,623.40	6,143,325,296,120.83
2.3.5	Эздийн өмчийн дүн	17,087,176,619,623.40	17,414,361,525,010.83
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,899,611,602,215.90	24,049,980,539,854.68

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,547,902,886,462.14	10,250,718,799,556.95
2	Борлуулалтын өртөг	2,153,348,581,516.28	1,917,458,166,356.27
3	Нийт ашиг(алдагдал)	7,394,554,304,945.86	8,333,260,633,200.68
4	Түрээсийн орлого	229,845,018.75	259,268,727.29
5	Хүүний орлого	20,565,532,101.92	112,522,187,700.56
8	Бусад орлого	114,447,142,052.75	207,450,366,672.07
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,223,690,324,291.44	2,186,913,032,368.92
10	Ерөнхий ба удирдлагын зардал	187,552,560,444.33	146,995,364,678.93
11	Санхүүгийн зардал	75,181,003,524.24	34,147,708,080.51
12	Бусад зардал	255,902,958,282.64	253,603,330,041.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(39,160,583,138.28)	(2,147,220,985.81)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(150,274,485.37)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,748,309,394,438.35	6,029,535,525,659.82
19	Орлогын татварын зардал	1,220,583,453,926.13	1,501,128,734,420.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,527,725,940,512.22	4,528,406,791,239.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,527,725,940,512.22	4,528,406,791,239.16
25	Орлогын нийт дүн	9,683,145,405,635.56	10,570,950,622,656.87

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ ний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	2,358,106,279,421.95	13,554,106,279,421.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	5,344,399,689.23	5,344,399,689.23
3	Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	2,363,450,679,111.18	13,559,450,679,111.18
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,527,725,940,512.22	3,527,725,940,512.22
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	5,891,176,619,623.40	17,087,176,619,623.40
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	220,141,885,258.27	220,141,885,258.27
11	Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	6,111,318,504,881.67	17,307,318,504,881.67
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	4,528,406,791,239.16	4,528,406,791,239.16
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	75,036,228,890.00	-	75,036,228,890.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	4,496,400,000,000.00	4,496,400,000,000.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	75,036,228,890.00	6,143,325,296,120.83	17,414,361,525,010.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөр ийн дуга ар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,509,699,726,615.75	9,643,858,236,406.18
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,448,250,568,240.78	9,625,078,878,246.54
1.1.6	Бусад мөнгөн орлого	61,449,158,374.97	18,779,358,159.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,141,078,196,770.92	6,537,208,393,474.58
1.2.1	Ажиллагчдад төлсөн	126,975,452,536.38	157,891,643,856.25
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	31,580,510,917.46	39,100,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,753,713,622,769.50	1,751,804,934,934.79
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	57,703,874.05	60,505,207.08
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	43,399,024,480.92	96,702,169,358.62
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	60,530,745,736.10	29,998,394,230.81
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,789,573,165,155.13	3,413,777,085,959.64
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,140,970,188.10	1,954,555,741.01
1.2.9	Бусад мөнгөн зарлага	334,107,001,113.28	1,045,919,104,186.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,368,621,529,844.83	3,106,649,842,931.60
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,930,778,760.70	43,804,316,047.23
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	10,930,778,760.70	43,804,316,047.23
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	690,799,709,687.77	1,537,280,431,665.75
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	111,869,457,337.60	224,486,284,821.05
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	710,695,187.50	522,246,769.50
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	578,219,557,162.67	1,312,271,900,075.20
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(679,868,930,927.07)	(1,493,476,115,618.52)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	490,990,884,718.00	1,741,092,447,572.17

3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	490,990,884,718.00	306,875,700,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	1,434,216,747,572.17
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(490,990,884,718.00)	(1,741,092,447,572.17)
4	Валютын ханшийн зөрүү	(18,910,810,134.00)	(5,197,096,929.23)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,178,850,904,065.76	(133,115,817,188.32)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	385,342,017,234.58	1,564,192,921,300.34
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,564,192,921,300.34	1,431,077,104,112.02

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он			
			Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	В	1	2	3	4	5
Олборлолт						
Уулын цул	мян.мЗ	102,666.4	151,428.6	155,452.4	4,023.8	102.7
Хөрс хуулалт	мян.мЗ	82,505.0	130,000.0	133,703.4	3,703.4	102.8
Нүүрс олборлолт	мян.тн	28,226.0	30,000.0	30,448.6	448.6	101.5
Хөрс хуулалтын коэффициент	мЗ/тн	2.9	4.3	4.4	0.1	101.3
Борлуулалт						
Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	29,303.3	31,604.0	29,639.5	(1,964.5)	93.8
<i>Үүнээс: Уурхайн ам нөхцөл</i>	мян.тн	-	13,038.5	18,277.4	5,238.9	140.2
<i>Хүргэж өгөх нөхцөл</i>	мян.тн	-	18,565.5	11,362.0	(7,203.4)	61.2
Борлуулалтын орлого	сая.\$		3,246.9	3,019.3	(227.6)	93.0
Борлуулах нүүрсний жинлэсэн дундаж үнэ	\$/тонн	95.3	102.7	101.9	(0.9)	99.2
Нийт орлого	сая ₮	9,683,145.4	11,573,656.5	10,570,950.6	(1,002,705.9)	91.3
Үүнээс: Нүүрс борлуулалтын орлого	сая ₮	9,547,902.9	11,201,646.6	10,250,718.8	(950,927.8)	91.5
Бусад орлого	сая ₮	135,242.5	372,009.9	320,231.8	(51,778.1)	86.1
Нийт зардал	сая.₮		6,214,322.0	4,541,415.1	(1,672,906.9)	73.1
Үйл ажиллагааны зардал	сая.₮	4,640,614.3	6,169,810.3	4,285,514.3	(1,884,296.0)	69.5
Борлуулсан бүтээгдэхүүний өтрөг	сая.₮	2,153,348.6	2,409,317.4	1,917,458.2	(491,859.2)	79.6
Борлуулалтын зардал (АМНАТ, гаалийн хураамж, хүргэж өгөх тээвэр, логистикийн зардал багтсан)	сая.₮	2,223,690.3	3,509,700.0	2,186,913.0	(1,322,787.0)	62.3
Ерөнхий ба удирдлагын зардал	сая.₮	187,552.6	218,861.1	146,995.4	(71,865.7)	67.2
Хайгуул үнэлгээ, судалгаа хөгжүүлэлтийн зардал	сая.₮	841.8	7,849.5	-	(7,849.5)	-
Санхүүгийн зардал	сая.₮	75,181.0	24,082.3	34,147.7	10,065.4	141.8
Үйл ажиллагааны бус зардал	сая.₮	10,362.6	44,511.7	12,961.1	(31,550.6)	29.1
Нийгмийн хариуцлагын зардал	сая.₮	6,220.7	42,451.2	11,307.4	(31,143.8)	26.6
Үйл ажиллагааны бус зардал	сая.₮	4,141.9	2,060.5	1,653.7	(406.8)	80.3
Бусад зардал	сая.₮	283,859.1		242,939.7	242,939.7	-
ААНОАТ-ын зардал	сая.₮	1,220,583.5	1,338,933.6	1,501,128.7	162,195.1	112.1
Цэвэр ашиг	сая.₮	3,527,725.9	4,020,400.9	4,528,406.8	508,005.9	112.6
Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж	сая.₮	3,098,603.5	2,933,258.1	3,499,577.6	566,319.5	119.3
Хөрөнгө оруулалтын төсөв	сая.₮	2,296,186.8	2,282,489.7	1,632,462.6	(650,027.1)	71.5

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 429.8 сая төгрөгийн нэг алдаа илэрснийг залруулах зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хангамжийн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 6 нэр төрлийн 429.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	429,862.9			1	429,862.9			1	429,862.9	1	429,862.9
Нийт дүн	1	429,862.9	-	-	1	429,862.9	-	-	1	429,862.9	1	429,862.9

3.2 Аудитаар нийт 38,869.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 34,371.3 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 4,498.6 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
								Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Төрийн өмчит компаниуд олгосон зээл, санхүүжилтээс тайлант онд эргэн төлөгдөх 25,775.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтрүүлсэн байна.	1	25,775,000.0			1	25,775,000.0						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2	Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй, нийгмийн шинж чанар бүхий 3 арга хэмжээнд нийт 671.9 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	671,926.2			1	671,926.2						
3	Компанийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй давхацсан чиг үүрэг бүхий хяналтын менежер, бүтээмжийн менежер, бизнес хөгжил хариуцсан менежерийг тус тус томилж, 2025 оноос эхлэн ажиллуулж, сарын үндсэн цалинг газрын даргын шатлалд дүйцүүлэн, цалингийн G7 шатлал буюу 7.5 төгрөгөөр тогтоосон байна.	1	-			1	-						
4	Тайлант онд 860.7 сая төгрөгийн нэг төрлийн болон ижил төстэй үйлчилгээний төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	1	860,700.0					1	860,700.0				
5	Санхүүгийн тайланд 2019 оны ногдол ашиг хуваарилалттай холбоотой 1,215.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын авлага, 2,817.8 сая төгрөгийн ногдол ашгийн өглөгийг хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгээгүй, барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.	1	4,033,068.5			1	4,033,068.5						
6	Уурхайн цэвэрлэх байгууламжийг Анверса ХХК-аар гүйцэтгүүлж, 8 сарын дотор ашиглалтад оруулахаар 2020 оны 5 дугаар 08-ны өдрийн ЭТТ-2020/328 дугаар гэрээ байгуулан, 1,690.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ч өнөөг хүртэл ашиглалтад ороогүй байна.	1	1,690,177.4			1	1,690,177.4						
7	Тус компани нь 2010-2024 онд байгаль орчны нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний барьцаа хөрөнгийг 1,336.2 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	1	1,336,165.0			1	1,336,165.0						

	хариуцсан эрх бүхий албан тушаалтантай тус тооцоог хийж, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.												
8	Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, төсөвгүй, тухайн арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн тайлангүйгээр тусгай цэсийн хоолны арга хэмжээнд 261.2 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	261,156.3			1	261,156.3						
9	Тус компанийн нийт үндсэн цалингийн 73.7 хувийг илүү цагийн хөлс эзэлж байгаа бөгөөд аудитын түүвэрт захиргаа, хүний нөөц, гэрээ эрх зүй, хэвлэл мэдээлэл, дотоод хяналтын хэлтсийн цалин хөлсийг хамруулж шалгахад зарим ажилтнуудын өдөрт ажиллавал зохих илүү цагийн хязгаарыг хэтрүүлэн тайлант онд 237.0 сая төгрөгийг бодож олгосон байна.	1	236,951.7			1	236,951.7						
10	Эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн програм нэвтрүүлэх талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд санхүүгийн програм худалдан авсан ч гэрээний хугацаанд бүрэн ашиглалтад оруулаагүй байна.	1	-			1	-						
11	Компанийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг бодитой, үр ашигтай байдлаар төлөвлөж батлуулаагүй, худалдан авах ажиллагааны алба, сургалт хариуцсан нэгжүүдийн уялдаа холбоо сул байгаагаас тайлант оны сургалтын төсөв 18.7 хувийн гүйцэтгэлтэй, мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй 42 сургалтад 366.9 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	366,890.0			1	366,890.0						
12	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2022, 2023 оны цэвэр ашгаас Төрийн өмчид ногдох 3,305.2 тэрбум төгрөгийн хувьцааны ногдол ашиг хуваарилсныг МУИХ-ын 10 дугаар тогтоол гарсантай холбогдуулан улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	-					1		-			

13	Нээлттэй цахим арилжаанд оролцсон 48 худалдан авагчтай байгуулсан гэрээний арилжааны үүрэг хангагдан, борлуулалтын орлогоо урьдчилан шилжүүлсэн байхад Монголын хөрөнгийн бирж ХК-ийн биржийн тусгай дансанд байршуулсан 588,906.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, тус мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах боломж алдагдсан байна.	1	-					1	-			
14	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүйгээр 2018 оноос эхлэн нийт 14 төсөл арга хэмжээнд 6,865,752.5 сая төгрөгийн эргэн төлөгдөх болон эргэн төлөгдөхгүй зээл, санхүүжилтийг олгосон байна. Тайлант онд 4 төсөл арга хэмжээнд нийт 693,924.1 сая төгрөгийг санхүүжилт олгосон байна.	1	-					1	-			
15	“Сая тонн-сая мод” хөтөлбөрийн хүрээнд тайлант онд 3,558.7 сая төгрөгийн 2.5 сая мод тарьсныг шууд зардлаар бүртгэсэн нь төрийн өмч хөрөнгөнд тавих хяналт алдагдах, хөтөлбөрийн үр дүнг тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.	1	3,558,679.7					1	3,558,679.7			
16	Дотоодын цэргийн 810 дугаар ангитай байгуулсан гэрээний дагуу 12.5 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлэх хугацаа хэтэрсэн байна.	1	12,491.5					1	12,491.5			
17	Уурхайн хотхоны барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар дүгнэлт гарсан боловч зарим дутуу ажлууд, зүгшрүүлэх ажлуудыг хэрэгжүүлээгүй, үүнтэй холбоотойгоор барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгээгүй, дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.	1	-					1	-			

18	Уурхайн захиргааны барилгын ажлын үр дүнгийн 3 жилийн баталгаат хугацаа 2025 онд дуусахаар байхад тус захиргааны барилгад шаардлагатай засвар үйлчилгээг хийлгээгүй байна.	1	-					1	-				
19	Уурхайн ажилчдын байр, орон сууцанд ашиглаж буй зөөлөн эдлэлийн бүртгэл, ашиглалт, хяналтад баримтлах бодлого байхгүй байна.	1	66,682.8					1	66,682.8				
Нийт дүн		19	38,869,889.4	-	-	10	34,371,335.3	9	4,498,554.0	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3 албан шаардлага хүргүүлж, 12 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн, үнэн зөв, ил тод мэдээлээгүй байна.	1	86,233,050.7	1	86,233,050.7		
	Дүн	1	86,233,050.7	1	86,233,050.7		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ нь ногдол ашгийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор хуваарилах хугацааг баримтлаагүй байна.	1	-			1	-
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын хэрэгцээ шаардлага, бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын урт болон дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулаагүй, санхүүгийн эх үүсвэр боломжийг бүрэн тооцоолж боловсруулан батлуулаагүй байна.	1	-	1	-		

3	Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн хугацааг баримтлаагүй, хугацаандаа хэрэгжиж буй эсэхэд тавих хяналт хэрэгжүүлдэггүй, зарим арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг тодорхой төлөвлөөгүй байна.	1		1			
4	Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын баримтыг түүвэрлэн үзэхэд үнэлгээний хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргадаггүй, зарим мэдээллийг дутуу хөтөлдөг, 1-ээс 2 сарын дараа нөхөн бүрдүүлдэг зэрэг зөрчил нийтлэг байна.	1		-		1	
5	Тайлант онд ам нөхцөлөөр борлуулсан нүүрсний хэмжээ биржээр борлуулсан хэмжээнээс өндөр байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиар тогтоосон уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах үндсэн зорилго алдагдах эрсдэлтэй байна.	1		-		1	
6	Төрийн өмчит компаниудын удирдлага, түүний эрх, үүргийг тодорхой зохицуулах эрх зүйн орчин дутмаг байгаа тул компанийн засаглал, удирдлага тэдгээрийн шийдвэр гаргалтуудын хоорондын уялдаа холбоо, хязгаарлалтуудыг хууль, дүрэмд тодорхой тусгаж мөрдөх шаардлага үүссэн байна.	1		-		1	
7	Орон тооны хэрэгцээ шаардлагыг бодитой тогтоохгүй байгаагаас шалтгаалан гүйцэтгэх захирлын тушаалаар орон тоо, ажлын байранд өөрчлөлт оруулсаар байна.	1		-		1	
8	Уурхайн төмөр замын нүүрс ачилт, буулгалтын талбайн камержуулалтын ажлыг гүйцэтгүүлэх ажил гэрээнд заасан хугацаанд хийгдээгүй 2 жилийн дараа буюу 2024 оны 12 дугаар сарын 23-нд тоног төхөөрөмжийг хүлээн авсан нь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлолгүйгээр худалдан авалт хийсэн байна.	1	436,540.1			1	436,540.1
9	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар санхүүжүүлэхийг хориглосон нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэхээр 10 төсөл, арга хэмжээнд нийт 1,495.7 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн түүвэрт хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийг шалгах явцад, нэг төрлийн болон ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг нэгтгэн багцалж төлөвлөлгүй, төсөвт өртгийг хэсэгчилж хуваан, шууд худалдан авалтын аргаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь холбогдох хууль, журмын заалттай нийцээгүй байна.	1		-		1	

10	ТӨБЗГ-аас тайлант онд 907,452.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нүүрс тээврийн 11 багцад ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тус худалдан авалтууд нь байгууллагын 2023, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.	1	907,452,865.1			1	907,452,865.1
11	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж дууссан байхад холбогдох төсөл, арга хэмжээний хувийн хэргийг архивын нэгж болгож хадгалаагүй, аудитын түүврээр сонгон үзсэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын хувийн хэргийн бүрдэл дутуу, зайлшгүй байх шаардлагатай зарим баримт бичгүүдийг тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хавсаргаагүй байна.	1	-			1	-
12	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний төслийг захиалга гаргасан газар, хэлтсийн мэргэжилтнүүд боловсруулж байгаа нь зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод заасантай нийцэхгүй байна.	1	-			1	-
13	Аудитаар түүвэрлэн шалгасан тендерүүдээс харахад захиалагч талаас шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэн өдрөөс хойш 10-29 хоногийн дараа талууд гэрээ байгуулж байна. Захиалагч талаас шалгарсан оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлдээ зургаагаас доошгүй өдрийн дараа гэрээ байгуулах хугацааг тодорхой тогтоож өгөөгүйгээс гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах хугацаа удааширсан байна.	1	-			1	-
14	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа материал, ажил үйлчилгээний зах зээлийн үнийн судалгааг ханган нийлүүлэлт, үнийн судалгааны хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд хийлгүй, захиалагч газрын хэлтсийн мэргэжилтнүүдээр боловсруулуулж байгаа нь компанийн бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй нийцэхгүй байна.	1	-			1	-
	Дүн	14	994,122,455.9	2	86,233,050.70	12	907,889,405.2
	Нийт дүн	15	994,122,455.9	3	86,233,050.70	12	907,889,405.2